

5

МОНГОЛ БҮРТГЭЛ: ХУВЬСАЛ БА ШИНЭТГЭЛ**Ч. Дашсамбуу**

Монголд энгийн бүртгэлээс ангид санхүүгийн мэдээллийн сан, хэмжлийн загвар байгаагүй, 1920 оноос давхар бичилтийн нягтлан бодох бүртгэл, 1930-аад онд түүхэн өртгийн хэмжил, мөнгөн суурьт санхүүгийн бүртгэл, 1940-өөд оноос зардлын төсөв, менежмент бүртгэлийн сууриуд тавигдсан. 1970-аад оноос бүртгэл мэдээллийг механикжуулах эхлэл тавьж, 1980-аад онд хэмнэлтийн данс, чекийн хяналт, норматив бүртгэл зэрэг шуурхай хяналтын хэлбэрүүдийг нэвтрүүлэхийг оролдсон ч олигтой үр дүнд хүрээгүй, 1990-ээд онд төвлөрсөн бүртгэлийн системийг халж, дэлхий, бүс нутгийн мэдээллийн даяаршилд нэгдсэн.

Шинэтгэлийн эхний шат \1993-2004\ нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрч, дэлхий нийтийн түгээмэл жишигт шилжих үзлийг төлөвшүүлэхэд чиглэж байв. Энэ зорилт олон цуврал арга хэмжээ, төслөөр амжилттай хэрэгжсэн. Юуны өмнө зохих мэргэжлийн удирдлага, хууль зүйн орчинг бүрдүүлж, монгол бүртгэлийн технологийг үндсээр нь эргэж хянах, мэргэжлийн боловсон хүчнийг шинээр бэлтгэх буюу давтан сургаж чанаржуулах шаардлага гарсан юм.

Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэл /1993/, Аудитын /1997/ Хуулиудыг баталж, Үндэсний нягтлан бодох бүртгэл, аудитын чадавхийг хөгжүүлэх хөтөлбөр, стратеги боловсруулж, зохих сургалт, судалгаа, туршилт бүхий олон шаттай төслүүд хэрэгжүүлсэн. Эдүгээ хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол улсын хуулиуд эдийн засгийн суурийн шинэтгэл, санхүүгийн тайлагналын орчинг өөрчилж, хувьсал дэвшлийг ахиулахад чухал үүрэгтэй юм.

Монгол Улсын Үнэт Цаасны Хороо, Улсын Татварын Ерөнхий Газар, Нягтлан Бодох Бүртгэлийн Мэргэжлийн Зөвлөл, Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт, хөндлөнгийн хяналтын итгэмжлэгдсэн албад зэрэг төр, олон нийт, хувийн хэвшлийн мэргэжлийн хяналтууд үүсч, Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоонд нэгдсэн.

Үндэсний нягтлан бодох бүртгэлийн системийг хөгжүүлэхэд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр,

Австралийн Засгийн Газар, бусад хандивлагчдын санхүүгийн дэмжлэг, буцалтгүй тусламж чухал үүрэг гүйцэтгэж ирлээ. Боловсон хүчний ур чадварыг хөгжүүлэхэд түлхүү анхаарч, их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөр шинэчлэн, мэргэжлийн боловсон хүчин, мэргэшсэн нягтлан бодогч-аудитор бэлтгэх, давтан сургах, шалгаруулах үндэсний тогтолцоог бүрдүүлсэн. 2004 оны дүнгээр Монголд 1200 орчим мэргэшсэн нягтлан бодогч байгаа нь нийт нягтлан бодогч, практик ажилтны 3 орчим хувь гэсэн үг.

Шинэ зууны босго дамнасан, дараагийн шатны зорилт шилжилт, бага оворын хөгжлийн эдийн засгийн онол, үндэсний маркетингийн стратеги, менежмент хэв шинж, философид нийцсэн үндэсний нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн системийн зохих стандарт, тайлбарыг эцэслэн бэлтгэж, бизнес орчин ба төсвийн байгууллагын хүрээнд бүрэн хэвшүүлэхэд оршино.

Системийн хэв шинж. Үндэсний түүх, соёлын өв, эдийн засгийн хэв шинж, уламжлал ба онцлогт нийцсэн мэдээллийн системийн хэв шинж, бүрдэл, бодлого зохицол ба хяналтын тогтолцоо чухамдаа манайд үгүйлэгдэж буй. Ялангуяа үндэсний мэргэжлийн хяналтын тогтолцоо ба хэв шинж, хууль, эдийн засаг, соёлын нөлөөг тандаж судлах нь чухал болов.

Монгол нүүдлийн соёл иргэншилт, алсын зайн нөлөөгүй, иргэний хуультай, шилжилт, бага оворын хөгжлийн эдийн засагтай улс гүрний бүлэгт багтана. Хөгжлийн ийм зурваст төрийн статустай мэргэжлийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь дэлхийн жишигт илүү нийцтэй юм. Тэгээд ч Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Арга зүй, Хяналтын Газрыг байгуулсан нь зөв алхам бөгөөд цаашид төрийн бус сектор, хувийн хэвшилд аажмаар шилжүүлэх болно.

Системийн хэв шинж, соёлыг Хофстед Геерт (1980), С.Ж Грейн (1988) загвараар оношлож, үнэлэмж илт доогуур төвшинд буйг (мэргэшүүлэх систем, ур чадварын өсөлт сул, нэг хэв загварын бодлого зохицол, хяналт муу, шинэтгэлд бэлэн бус, хэвшсэн практикийг илүүтэй үздэг, мэдээллийн ассиметрик шинж, далд эдийн засаг, авилгал, хууль бус үйлдэл газар авсан) тогтоов. Системийн үнэлэмжийг өсгөх чиглэлд төр засгаас явуулах бодлогын чиглэл: *нэгд*, Улс төр, эдийн засаг, хуулийн орчинг эрүүлжүүлэх, *хоёрт*, “Судалгаа-хэрэгжилт-хяналт” мөчлөгт бодлого, зохицол, хяналтын нөлөөг дээшлүүлэх, *гуравт*, Системийн тунхаг, стандарт, тайлбарыг нэг мөр бэлтгэж, бизнес, төсвийн хүрээнд хэвшүүлэх, *дөрөвт*, Мэргэшүүлэх систем, сургалтын нөлөөг дээшлүүлэхэд оршино.

Системийн бодлого зохицол, хяналтын бүдүүвч:

Эрх зүйн орчин

Системийн тунхаг, стандарт, тайлбар

Хяналт, бодлого зохицол, зохион байгуулалт: (дүрэм, заавар, журам, аргачлал)

Байгууллага, нэгжийн бүртгэлийн бодлого.

Нягтлан бодох бүртгэлийн системийг дэлхийн жишиг, олон улсын стандартад нийцүүлэх шинэтгэл манайд 1995 оноос эхэлсэн. Гэвч нягтлан

бодох бүртгэл, аудитын олон улсын стандартыг тэр хэвээр нэвтрүүлэхээр оролдож ирсэн. Хөгжлийн ялгаа, үндэсний хэв шинж, онцлог, банк зээлийн харилцааны уламжлал зэрэг олон учир шалтгаануудын улмаас тэр бүр таарч тохирохгүй зүйл олон байсан.

Манайд түрээсийн харилцаа, үнэт цаасны зах зээл сайн хөгжөөгүй, давуу эрхийн хувьцаа, хөрвөгч үнэт цаас, опцион, хувьцааны эрх зэрэг онцгой чадамжит үнэт цаасны багц хэвшээгүй, өмчийн нийлмэл бүтэц үүсээгүй байна. Үндэсний нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн загварчлалд дараах онцлогуудыг тусгах нь зүйтэй юм. Үүнд:

- Аж ахуйн нэгж, байгууллагын цар хүрээ, хөрөнгө, эх үүсвэрийн бүтэц, хэмжээ
- Бүртгэлийн мэргэшсэн ажилтнуудын мэргэжил боловсрол, туршлага, ур чадвар
- Мэдээлэл боловсруулалтын горим (гар, компьютерт суурилсан гар ажиллагаатай, компьютерээр гэх мэт)
- Мэдээлэл хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага зэрэг байж болох юм.